МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 22 өдөр Дугаар А/324 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, спорт заал, сурагчдын дотуур байр, Хүн эмнэлгийн уурын зуухны үйл ажиллагаатай танилцаж ажиллаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мягмарсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга, техникийн хяналтын улсын байцаагч) - зөвшилцсөнөөр

Гишүүд:

Д.Аюушжав (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга, техникийн хяналтын улсын байцаагч) - зөвшилцсөнөөр

Б.Чулуунбаатар (Аймгийн Ус суваг, нийтийн аж ахуйн компанийн Засвар үйлчилгээний инженер) - зөвшилцсөнөөр

Н.Эрдэнэдаваа (Хөвсгөл дулаан станц ТӨХК-ийн Горимын тооцооны инженер) - зөвшилцсөнөөр

2. Тухайн барилга, байгууламжид үүссэн хүндрэлтэй нөхцөл байдалд үнэлгээ өгч цаашид хэвийн үйл ажиллагааг хангахад авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулж 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Мягмарсүрэн)-т даалгасугай

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2022